

ОЛОН УЛСЫН АСУУДЛЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ НЬ:
ТУРШЛАГА БА ХАНДЛАГА

Б.Наранбаатар*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: эрэн сурвалжлах сэтгүүл зүй, олон улсын сэтгүүл зүй, мэдээллийн орчин, ОНМХ, гадаад мэдээллийн бодлого, Интернет, орчин үеийн даяар асуудлууд

Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, мэдээллийн даяар үйл явцын хандлагыг даган өөрчлөгдөж буй олон нийтийн мэдээлэл харилцааны шинэ хэрэгслүүд, тэдгээрийн хэрэглээний давамгайллын үр дүнд уламжлалт сэтгүүл зүй, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа шинэ нөхцөлд дасан зохицох, хувьсан өөрчлөгдөх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Зөвхөн Монголд гэлтгүй, олон улс оронд тогтмол хэвлэлийн захиалга, борлуулалт буурч, телевизийн "цэвэр сэтгүүл зүй"-н нэвтрүүлэг, мэдээллийн орон зай шахагдан инфо-тайнмент шинж чанар давамгайлах болсон нь өнөөгийн ОНМХ-ийн зах зээлийн үнэн төрх мөн. Энэ нөхцөлд хэрэглэгчийн мэдээлэл хүлээн авч буй олон хэрэгслээс мэргэжлийн сэтгүүл зүй юугаар онцгойрч олон нийтийг татах вэ, хадгалж үлдэх вэ гэсэн асуулт онол, практикийн түвшинд маргаан дагуулсаар нэлээд хугацааг үдлээ. Маркетинг, менежмен-

тийн түвшинд багагүй алхмууд хийгдэж, шинэ гарцууд эрэлхийлэн, хэрэгжүүлж байгаа боловч, чанартай сэтгүүл зүйг тодорхойлогч өдөр тутмын сонин, телевизийн мэдээллийн хөтөлбөр, ярилцлага хэлэлцүүлгийн нэвтрүүлгүүд нь хэрэглэгчийн хандлагын үүднээс авч үзвэл олон нийтийн сүлжээ, мэдээллийн портал сайт, эсвэл телевизийн олон ангит кино, цэнгээнт нэвтрүүлгүүдэд "ялагдсаар" удлаа. Өөрөөр хэлбэл, ОНМХ-ийн мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь "сүүлд ургасан эвэр"-тээ гүйцэгдэж, сэтгүүл зүйн бус мэдээлэл харилцаа энэ талбарт ноёлох болсон байна.

Монголын арилжааны телевизүүд мэдээллийн хөтөлбөр, түүний чанар чансаа, баримтат нэвтрүүлэг, ярилцлага, хэлэлцүүлгээрээ бус, гадаадын олон ангит кино, орчуулгын цэнгээнт шоу нэвтрүүлгүүдээрээ өрсөлдөж эрэмбээ тогтоодог болж буй нь дээрх үндэслэлийг батлах мэт. Олон улсын түвшинд ч энэ хандлага ажиглагдах бөгөөд барууны томоохон хэвлэлүүд Интернет, мэдээллийн технологид түшиглэсэн мультимедиа төслүүддээ анхаарал тавих болсон, сэтгүүл, телевизийн салбарт энтертайнтент мэдээллийн сувгууд хүртээмж, хөрөнгийн

эргэлтээр тэргүүлж байгаа нь мөн л дээрхийн баталгаа. Гэвч сэтгүүл зүйн мэдээлэл, нийтлэл нэвтрүүлгийн байнгын хэрэгцээнд эргэлзэх шаардлагагүй бөгөөд харин энэ чиглэлд ач холбогдол, үнэ цэнийг өсгөх, шинэ хэрэгцээг бий болгон төлөвшүүлж, хөгжүүлэх нь орчин үеийн сэтгүүл зүйн гол гарц юм.

Монголын ОНМХ-үүдийн хувьд энэ тэргүүнд шинэчлэн өөрчилж, нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо тусган анхаарал хандуулах ёстой чиглэл бол гадаад мэдээ, мэдээллийн чиг баримжаа юм. Олон улсын үйл явдал, үзэгдлийн талаарх мэдээлэл нь Монголын мэдээллийн хэрэгслүүдэд уламжлалаа даган оршоор байгаа боловч ямар ч редакцийн бодлогогүй, цаад мөн чанарын илэрхийлэлгүй, үзэгч, уншигчийн хувьд ач холбогдолгүй, идэвхгүй мэдээллийн орон зай болж хувираад удаж байна. "Байвал илүүдэхгүй, байхгүй бол үгүйлэгдэхгүй" гэдгийн үлгэр чухам энд илэрч буй. Энэ сэдвийн хүрээнд санал, шүүмж ховорхон боловч мэргэжлийн хүрээнд хэлэлцэгддэг ч сэтгүүл зүйн салбарт бугшсан бусад "өвчлөл"-ийн ярианы сүрэнд дарагдаж, ач холбогдол нь замхарсаар байна. Гэтэл даяар мэдээлэл, харилцааны чиг хандлагын хувьд олон улсын түвшний үйл явдал, асуудлын үнэ цэн харин ч өсөн нэмэгдэгдэж, дотоод гадаад мэдээллийн ач холбогдол энэ зэрэгцэх болсон ба нийгэм-эдийн засгийн интеграцийн үр нөлөө улс орон бүрийн дотоод бодлого, аж амьдралд тусч буйг мэдрэхгүй өнгөрөөсөөр байж боломгүй.

Монголын чанартай хэвлэлийн нүүр царай болж буй өдөр тутмын сонинууд, иргэдийн мэдэх хэрэгцээг хангах үндсэн суваг болсон телевизийн мэдээллийн хөтөлбөрүүдийн гадаад мэдээ, мэдээллийн талбар дахь нийтлэг

дутагдал нь асуудал, үйл явдлыг өнгөц дурдаад өнгөрөх, эх сурвалжийн мэдээллийн өнцгийг шууд орчуулгаар монгол үзэгч, уншигчид хүргэх зэрэгт оршиж байна. "Хэзээ, хаана, хэн, юу?" гэх асуултанд хариулсан мэдээллийн түвшинд өдөр тутмын сонин, телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд ч мультимедиа хэрэгслүүдээс хол хочорч буйгаа ухаарч, илүү задлан шинжилсэн, дүгнэсэн, танин мэдүүлсэн, магадгүй ухааруулсан нийтлэл, нэвтрүүлгүүдийн орон зайг нөхөх хэрэгцээ, шаардлага, цаг хугацаа цогцоороо бүрдээд байна. Энэ нь гадаад дотоод мэдээ, мэдээллийн аль ч урсгалд хамаатай ба чухам энэ л мэргэжлийн сэтгүүл зүйн үлдэж хоцрох үүр, ичээ нь мөн юм.

Дэлгэрэнгүй үндэслэл тавьсны эцэст дэвшүүлсэн сэдвийнхээ агуулгад оръё. Орчин үеийн сэтгүүл зүйд буй нэгэн хандлага нь сэтгүүл зүйн олон бичлэгийн төрөл зүйл, нийтлэл, нэвтрүүлгийг бүтээх, түгээх арга хэрэгсэл, тодорхой сэдэвт чиглэлүүд уусан нэгдэх, хавсарга, нийлмэл шинжтэй чанартай болж буй үзэгдэл. Чухам энэ сэжүүрт зохиогч миний бие Монголын ОНМХ-үүдийн гадаад мэдээ, мэдээллийн хүртээмж, ач холбогдолд гэрэл нэмэх нэгэн чиглэл буйг санал болгохын зэрэгцээ уг өгүүллийн сэдвийн томъёоллоор утвар болгон дэвшүүлсэн болно.

Олон улсын үйл явдал, асуудал, үзэгдлийг сэтгүүл зүйн эрэн сурвалжлах чиглэлтэй холбоно гэдэг угаас шинэ санаа биш авч Монголын нөхцөлд зайлшгүй хэрэгцээ бүхий чиг баримжаа гэдгийг энгийн уншигч, үзэгчийн хувиар ч, сэтгүүл зүйн салбарт судалгаа хийж яваа хүний хувиар ч ийнхүү тодотгож байна. Сэтгүүл зүйн ерөнхий онол, эрэн сурвалжлах сэтгүүл

зүйн үзэл баримтлалын үүднээс авч үзвэл эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гол объект нь тухайн улсын дотоодын асуудал, үзэгдэл байдаг. Өөрөөр хэлбэл, аливаа улсад олон нийтээс нуун дарагдуулж, тэдний эрх ашигт харшилж буй мэдээлэл, баримт, үйл явдлыг сэтгүүлчийн үйл ажиллагаагаар олон нийтэд дэлгэх, үргэлжлүүлэн мөрдөхөд энэ чиглэлийн амин сүнс нь оршдог. Монголын ОНМХ-үүд, сэтгүүлчид дотооддоо эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх нөхцөл, бололцоо алга хэмээн "гомдоллож" байгаа өнөө үед юун олон улсын асуудлыг "мөшгих" вэ хэмээн эргэлзэх хүн байх нь магад. Гэвч Монголын ОНМХ-үүдийн идэвхгүй, ач холбогдолгүй мэдээллийн урсгал болон хоцорч буй "гадаад мэдээ" гэсэн "ялгаварлан гадуурхагдсан" тодорхойлолттой нийтлэл, нэвтрүүлгийн орон зайг иргэдийн анхаарал, сонирхлыг татах, сэтгүүлчийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэх нэгэн сэжүүр болгох боломжтой гэсэн санаагаа доор сийрүүлэе.

Олон улсын асуудлыг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн судалгаа, нийтлэлийн объект болгох эхлэл 1970-аад оны сүүл үеэс тавигдсан бөгөөд үндэстэн дамнасан корпорациудын ноёрхол, олон улсын терроризм, гэмт хэрэг, засгийн газар, нууц албадын "далдлан эвссэн" хууль бус үйлдлүүд нь олон орны сэтгүүлч, ОНМХ-үүдийг нэгдэн ажиллах, улс орны хил хязгаарыг давсан сэдвийг мөрдөн "мөшгих" үндэслэл болсон гэдэг¹.

Анх 1978 онд Их Британийн хэсэг эрдэмтэн: "Дэлхий даяар радио тагнуулын хууль бус ажиллагаа явуулдаг олон улсын сүлжээ бий болсон" хэмээн мэдэгдсэнээр дуулиан дэгдэж, Засгийн газар, холбогдох

байгууллагууд энэ мэдээллийг няцааж байв. Хожим нь эдгээр эрдэмтэн төрийн нууцын хэрэгт "унаж" баривчлагдсан байдаг. Харин энэ сэжүүрийг "Гардиан" сонины сэтгүүлч Дункан Кемпбелл, Шинэ Зеландын сэтгүүлч Ники Хэгер, Францын "Лө пуан" сэтгүүлийн Жан Гуисне нар олон жилийн турш баримт, мэдээлэл цуглуулан баталж, олон улсын асуудлыг эрэн сурвалжлах ажлын шанг татжээ. Үр дүнд нь "Эшелони хэрэг" хэмээн алдаршсан радио тагнуулын үйл ажиллагааны талаар АНУ, Их Британи, Австрали, Канадын тагнуулын байгууллагууд "хэргээ хүлээж", НАТО-гийн хүрээнд хамтрагч Европын орнуудад шуугиан тарьж байлаа².

Улмаар 1997 онд Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум (International Consortium of Investigative Journalists, ICIJ, <http://www.icij.org>) гэх байгууллага бий болж, 40 гаруй орны 160 орчим сэтгүүлч, ОНМХ-ийг нэгтгэсэн бөгөөд өдгөө олон улсын сэдэв, үйл явдлыг эрэн сурвалжлах ажилд хамтран ажиллах, тусалцаа үзүүлэх, шагнаж урамшуулах зэрэг үндсэн чиглэлээр ажиллах болжээ. ICIJ нь АНУ-ийн Нийгмийн шударга ёсны төлөө төв* (Center for Public Integrity)-ийн үйл ажиллагааны томоохон салбар чиглэл бөгөөд хоёр жилд нэг удаа шилдэг олон улсын эрэн сурвалжлагыг шалгаруулж, Пакистанд амиа алдсан америкийн сэтгүүлч Даниел Перлийн** нэрэмжит шагнал олгодог байна³.

Олон улсын асуудлыг эрэн сурвалжлах ажил нь цаг хугацааг даган хувьсаж, хөгжлөөр, тогтолцоогоор ялгаатай дэлхийн улс орнуудад өөр өөр өнгө аясаар хөгжин төлөвшиж байгаа ба тодорхой үзэл баримтлал, онол, арга зүйн суурь ч бий болжээ. Тухайлбал, хөгжиж буй улс оронд

бусад улс орны туршлагаас суралцах, алдаа оноог судлан, түүнээс зайлсхийх, нийгэм-эдийн засгийн бодлогоо шинэчлэн өөрчлөхөд ч олон улсын эрэн сурвалжлага үр нөлөөтэй гэж үзэх болсон байна. Өөрөөр хэлбэл, олон улсын үйл явдал, үзэгдлийг эрэн сурвалжлахад нийтлэл, нэвтрүүлгийн объект нь заавал "нууцалсан", "олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн" байх шаардлагагүй аж. Тийм байвал сайн, гэхдээ албагүй. Энэ утгаараа Филиппин, Малайз, Индонези эхтэй "Хөгжлийн сэтгүүл зүй" буюу улс орныхоо хөгжилд нэмэр болох арга, туршлага, санаачилгыг эрэлхийлдэг сэтгүүл зүйн хэлбэр ч энэ хүрээнд багтан орж ирэх нь⁴.

Иймд олон улсын асуудлыг эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлгийн сэдэв, судалгааны цар хүрээг дараах байдлаар томъёолж болно. Үүнд:

- Улс орны дотоод бодлого, үйл явцад нөлөөлөх гадаад хүчин зүйл, үйл явдал, үзэгдэл;
- Гадаад орны бодлого, шийдвэр, үйл явдлын тухайн улс орон дахь үр дагавар, нөлөөлөл;
- Улс дамнасан гэмт хэрэг, авлига, хууль бус үйлдлийн сүлжээ;
- Тухай улс орны нэгдсэн олон улсын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилт ба гажуудал;
- Тухайн улсын гадаад имиж, ухуулга сурталчилгааны үр нөлөө;
- Ижил төстэй улс орнууд, нийгэм-улстөр-эдийн засгийн нөхцөл байдлын бодлого, шийдвэр, арга туршлага;

- Орчин үеийн даяар асуудлуудын тархалт, нөлөө, тэдгээрийг танин мэдүүлэх;

- Улс дамнасан корпораци, компаниудын үйл ажиллагаа, шударга өрсөлдөөн;

- Түүхийн зангилаа асуудлууд, гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүх, үр дүн;

- Даяар үнэт зүйлсийн төлөвшил, гажуудал, эерэг сөрөг тал гэх мэт.

«

Мэдээллийг сонирхолтой болгохын тулд, эсвэл өөрийн байр суурийг тодотгохын тулд гаоны баримт, жишээг хэрэглэхдээ харууцлагагүй хандаж, илт гуйвуулах, дэсдүүлэх, эсвэл баримтыг үнэгдүүллэх хандлага манай сэтгүүлчдэд ажиглагддаг. Дотоод үйл явдлын баримтад ийм зүйл харьцангуй бага

»

Дэвшүүлсэн сэдвүүдийн хүрээнд Монголын ОНМХ-үүд нийтлэл, нэвтрүүлгүүд тохиолдлын шинж чанартай, асуудлыг өнгөц танилцуулсан байдлаар гардаг боловч хэт хүртээмжгүй, залгамж чанар үгүй, задлан шинжлээгүй зэрэг дутагдал бий. Эдийн засаг, га-

даад харилцаа, эрчим хүч уул уурхайн бодлоготой холбоотой сэдвүүдээр мэргэшсэн зарим сэтгүүл (Mongolian Mining Journal, Mongolian Economy г. м.) нийтлэлүүд бичиж, өдөр тутмын сонинууд "будaa идэх" зарчмаар дээрх орон зайг нөхөж байна. Мөн news.mn-ын нийтлэлчийн булантай хамтран ажилладаг зарим нийтлэлч дээрх сэдвүүдийг заримдаа шүүрч авдаг ч мөн л судалгаа, задлан шинжилгээ дутуу, өөрийн эсвэл нэг талыг баримтласан байр суурийг хэт тулгасан, баримт жишээг өөрийн өнцөгт тааруулж "хувиргадаг" зэрэг сул тал байна.

Олон улсын үйл явдал, үзэгдэл, баримтыг дотоодын уншигч, үзэгчид хүргэхэд бодит баримт, тайлбар нэн

чухал. Мэдээллийг сонирхолтой болгохын тулд, эсвэл өөрийн байр суурийг тодотгохын тулд гадны баримт, жишээг хэрэглэхдээ хариуцлагагүй хандаж, илт гуйвуулах, дэгсдүүлэх, эсвэл баримтыг үнэгүйдүүлэх хандлага манай сэтгүүлчдэд ажиглагддаг. Дотоод үйл явдлын баримтад ийм зүйл харьцангуй бага. Ядаж л бусад сэтгүүлчид, ОНМХ-үүд "хянаж" байдаг учир хариуцлагаа мэдэрдэг. Харин гадны баримт жишээг "Намайг хэн шалгах вэ?" гэсэн хандлагаар орчуулсан, орчуулуулсан, эсвэл дам сонссон эх сурвалжаар ашиглах нь бий. Ийм баримт жишээ нэлээд олддог ба зөвхөн гадаад мэдээний нүүр, эсвэл хөтөбөрт ажиглагддаг гэвэл хилс болно.

Олон улсын асуудлыг эрэн сурвалжлах зохиогчийн дэвшүүлсэн сэдэв чиглэлийн хүснэгтэд мэдээллийн эх сурвалж, баримтын олдоц энэ цаг үед харьцангуй сайн байгаа бөгөөд зарим тохиолдолд санхүүгийн болон бусад дэмжлэг авах боломж ч Интернет орчинд сэтгүүлчдэд нээлттэй болжээ. Иймд редакцийн гадаад мэдээ, мэдээллийн бодлогод эрс өөрчлөлт оруулж дэлхийн үйл явдал, амьдрал, өөрийн эзлэн буй байр суурийг иргэддээ ойртуулах нь зарын нүүрнээс үнэ цэнгүй болж хувирсан сонины гадаад мэдээний булан, зар сурталчилгааны блокоос сонирхолгүй, идэвхгүй болсон гадаад мэдээллийн хөтөлбөрийг "аврах" гарц нь юм. Үүний тулд, редакцидад зайлшгүй хийгдэх шаардлагатай өөрчлөлт, шийдвэр бий. Заримаас нь тоймловол: 1-рт, өдөр тутмын сонин, телевизийн мэдээллийн хөтөлбөр дэх "гадаад мэдээ" хэмээх заагийг арилгаж, гадаад үйл явдлын мэдээллийг ач холбогдлын дагуу хуваарилан бусад

буланд шингээх, 2-рт, дээр дэвшүүлсэн сэдэв чиглэлийн хүрээнд илрүүлсэн баримт, үйл явдлыг зөвхөн задлан шинжилсэн байдлаар хэрэглэгчдэд хүргэдэг эфирийн цаг, сонины нүүртэй болох чиглэлд редакцийн бодлогод тусгах, 3-рт мөн олдсон баримт, мэдээллийг дотоод нийтлэл, нэвтрүүлгийн явцад идэвхтэй ашиглах тал дээр хамтран ажиллах, 4-рт гадаад мэдээллийн эх сурвалжуудтай байнгын харилцаа тогтоох, хамтран ажиллах, сэтгүүлчдийг мэргэшүүлэх тал дээр редакцийн удирдлага тодорхой бодлого боловсруулах зэрэг санал байж болно. Мөн Монгол Улсын талаарх бодит мэдээллийг бусад улс оронд түгээх дам "үүрэг" хүлээж буйн хувиар томоохон ОНМХ-үүд "Тэд бидний тухай ингэж бичлээ, ярилаа" хэмээсэн буцах-орчуулга хийхийн оронд, гадны мэдээллийн хэрэгслүүдийн хувьд өөрсдөө Монголын тухай мэдээллийн байнгын эх сурвалж болох талаар анхаарах нь зүйтэй юм.

Уламжлалт мэдээллийн хэрэгслүүдийн дор хаяж хагас өдрийн хоцрогдолтой олон нийтэд хүрч буй гадаад мэдээллийн булангийн үнэ цэнийг дээшлүүлэх үндсэн гарц нь энэ хэмээн зохиогч таамаглаж байна.

Ишлэл

¹ Константинова А. Д. 2003. Журналистское расследование: история метода, современная практика. ОЛМА-Пресс. Москва, с. 36

² Райт Стив. Развитие технологий слежки, <http://jedi.kosnet.ru/sorm/stoa1.html>, «Эшелон» в Европарламенте.

³ International Consortium of Investigative Journalists. www.icij.org – хянасан 2014.11.15

⁴ Center for public integrity. www.publicintegrity.org – хянасан 2014.11.15

• Нийгмийн шударга ёсны төлөө төв (Center for Public Integrity) – АНУ-д 1989 онд байгуулагдсан эрэн сурвалжлах сэтгүүлчдийн хамтын ажиллагааг дэмжих хараат бус байгууллага. Үндэслэгч нь Чарльз Льюис.

• Даниел Перл (Daniel Pearl) – АНУ-ын Wall Street Journal сонины сэтгүүлч агсан. 2002 оны 1-р сарын 23-нд Пакистаны Карачи хотоос хулгайлагдаж, 2-р сарын 1-нд цаазлагдсан. Пакистаны тусгаар тогнолыг сэргээх үндэсний хөдөлгөөн хэмээх экстремист бүлэглэлийн дайчид Даниел Перлийг барьцаалж, АНУ-ын Засгийн газраас Гуантанамод хоригдож буй Аль-Каидагийн дайчдыг суллахыг шаардаж байв. 2003 онд ICIJ түүний нэрэмжит шагнал бий болгожээ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2008. Мировая политика и международные отношения. Под. ред. С. А. Ланцова, В. А. Ачкасова. М.

2. Нургалиева Л. 2006. Актуальные проблемы человечества и СМИ. М.

3. Константинова А. Д. 2003. Журналистское расследование: история метода, современная практика. ОЛМА-Пресс. М.

4. Зулфикарий М. 2007. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. УБ.

5. Наранбаатар Б. 2011. Освещение глобальных проблем современности в СМИ Монголии // Автореф. дисс. канд. фил. наук. М.

Резюме

Данная статья посвящена вопросу о журналистском расследовании на международные темы, о необходимости его развития в монгольских СМИ. Автор статьи рассматривает возможности продвижения освещения международных событий монгольскими СМИ на фоне развития глобальных информационных процессов и технологий, предлагает своё видение решения проблем неэффективности и незначимости международных сообщений в ежедневных газетах и телевизионных информационных выпусках.